

МОНГОЛ УЛСЫН  
ДЭЭД ШҮҮХ

2025



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН СТРАТЕГИЙН ЗОРИЛТ:

**"ШҮҮХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧАНАР,  
ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛНЭ"**

## УЛСЫН ДЭЭД ШҮҮХ

Өмнөхүг	4
Улсын дээд шүүхийн бүрэлдэхүүн	6

## ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ ТООН МЭДЭЭЛЭЛ

Танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцсэн хэрэг	8
Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэрэг	9
Хяналтын журмаар гаргасан гомдлыг танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэх процесс	10
Хяналтын шатны шүүх хуралдаанаар хэрэг хянан шийдвэрлэх процесс	11
Хэрэг хянан шийдвэрлэсэн дундаж хугацаа	12
Улсын дээд шүүхийн шийдвэрийн тойм	13

## ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНААС БУСАД АЖЛЫН ТООН МЭДЭЭЛЭЛ

Нийт шүүгчийн хуралдаан, Шүүгчдийн зөвлөгөөн	16
--	----

## ЧУУЛГАН, ОЛОН УЛСЫН ХУРАЛ, УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Нийт шүүгчийн ээлжит III чуулган	18
“Шүүхийн хараат бус байдал ба цахимжилт” сэдэвт олон улсын бага хурал	19
“Дагнасан шүүхийн тогтолцоо: Хүүхдийн эрх ашиг ба гэр бүл” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал	19
“Шүүхийн ил тод байдал - Хэвлэл мэдээллийн хамтын ажиллагаа” сэдэвт уулзалт	20
“Шүүхийн цахимжилт, шууд дамжуулалт”-ын талаар сэтгүүлчидтэй хийсэн уулзалт	20
“Шүүхийн шийдвэр бичих аргачлал: шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой тогтоох хэсэг” уулзалт	21
“Сэтгэгцэд учруулсан хор уршгийг арилгуулах эрх зүйн орчин: “Асуудал, шийдэл” сэдэвт хэлэлцүүлэг	21
“Татварын маргаан шийдвэрлэх чадавхыг дээшлүүлэх” сургалт, хэлэлцүүлэг	21

## ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Бенилюксийн орнуудад хийсэн албан ёсны айлчлал	22
Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Ардын дээд шүүхтэй санамж бичиг байгууллаа	22
Бүгд Найрамдах Сингапур Улсын дээд шүүхтэй санамж бичиг байгууллаа	22
Шүүх засаглалыг бэхжүүлэх Европын Холбооны Твиннинг хөтөлбөрийн хэрэгжилт	23
“Тэгш эрх, шударга ёсыг хүн бүрд” төслийн хэрэгжилт	23

## УЛС ТӨРИЙН НАМЫН БҮРТГЭЛ

“Улс төрийн намын дүрмийн нэмэлт, өөрчлөлт (шинэчилсэн найруулга)-ийг бүртгүүлэхэд анхаарах асуудал” сэдэвт уулзалт	24
Улс төрийн намын бүртгэлийн тоон мэдээлэл	25

## ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛД

Шүүгч болон хуульчдад зориулсан сургалт	26
Олон нийтийн эрх зүйн боловсролд	27

## УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

Шүүх хуралдааны шууд дамжуулалт	30
Шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдал	31
Мэдээллийн технологи, цахимжуулалт	32
Улсын дээд шүүх байршлаа өөрчиллөө	33
“Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэг”-т хамрагдлаа	34



## ӨМНӨХ ҮГ



Эрхэм уншигч танаа.

Улсын дээд шүүхээс өмнөх жилийн үйл ажиллагааныхаа тайланг хураангуй товхимол хэлбэрээр 3 дахь жилдээ нийтлэн таны гарт хүргэж байна. 2025 он шүүх эрх мэдлийн хувьд олон шинэ өөрчлөлт, ололт амжилттай, тэмдэглэж үлдээх үр дүнтэй жил болсныг онцлох нь зүйтэй.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш шүүхийн хүний эрхийг хамгаалах чадамж, үйл ажиллагааны чанар, үр нөлөөг улам дээшлүүлж, иргэдийнхээ итгэлийг хүлээсэн, олон улсад нэр хүндтэй институт болж хөгжих олон талт бодлогыг бид эрчимтэй хэрэгжүүлж ирсэн. Энэ хүрээнд бий болсон олон томоохон үр дүнг өнгөрөгч 2025 онд Нийт шүүгчийн III чуулганаар хэлэлцэж дүгнэв.

Шүүхийн тогтолцоог шинэчилж хараат бус, ил тод байдал, сахилга хариуцлагыг дээшлүүлэх механизмыг тодорхой хугацаанд туршсаны үндсэн дээр улам төгөлдөржүүлэхийн зэрэгцээ цаашид чанарын дэвшилд илүү

анхаарах боломж бүрдсэн байна. Чуулганы үеэр хуульд заасан процессын журам, шүүх эрх мэдлийн зарим байгууллагын тайланг хэлэлцэж, шинэтгэлийн үр нөлөө, салбарын цаашдын хөгжлийн асуудлаар шүүгч бүр дуу хоолойгоо хүргэж хамтын удирдлага, дотоод ардчиллын үндсэн дээр шийдвэрээ гаргав.

Шүүхийн үйл ажиллагааны орчин нөхцөлийг сайжруулах хүрээнд Улсын дээд шүүх байршлаа өөрчилж Хангарди ордныг шүүхийн зориулалт, стандартад нийцүүлэн шинэчилснээс гадна тухайн байранд шүүх хуралдааныг шууд дамжуулах, цахим сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, нэвтрүүлэг бүтээх, кибер, тэр дундаа өгөгдлийн аюулгүй байдлаа хангах цогц дэд бүтцийг угсарсан нь түүхэн ач холбогдолтой арга хэмжээ боллоо.

Өнгөрсөн нэг жилийн хугацаанд Улсын дээд шүүхэд хиймэл оюун нэвтрүүлэх суурь судалгааг гүйцэтгэж, хяналтын шатны шүүх хуралдааны тогтоолуудыг оновчтой формат руу (json) хөрвүүлэн өгөгдлийн сангаа бүрдүүлэв. Мөн дотооддоо synology төрлийн сүлжээний хадгалах төхөөрөмж суурилуулж чанарын шаардлага хангасан дата төв байгууллаа. Программ хангамж талаасаа “Улсын дээд шүүхийн дотоод нэгдсэн систем”-ээс гадна Шүүх бүрэлдэхүүн, илтгэгч, даргалагч шүүгчийг сонгох, Улс төрийн намын бүртгэл хийхэд шаардлагатай системүүдийг хэрэглээнд нэвтрүүллээ. Үр дүнд нь байгууллагын цахимжилт дараагийн түвшинд шилжиж, Улсын дээд шүүхийн үйл ажиллагаанд хиймэл оюун нэвтрүүлэх суурь бэлтгэл хангагдсан байна.

Ил тод байдлаа дээшлүүлэх бодлого үе шаттайгаар хэрэгжиж өнгөрсөн 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Улсын дээд шүүхийн санаачилга, хууль тогтоогчийн дэмжлэгтэйгээр батлагдсан “шүүх хуралдааныг шууд дамжуулах” ажиллагаа улс даяар хэрэгжиж эхэлсэн. Улсын дээд шүүхээс дуудүрсний өндөр чанартайгаар хяналтын шатны нийт 564 шүүх хуралдааныг цахим хуудас, фейсбүүк пейжээр дамжуулав. Мөн эл хугацаанд шүүх хуралдааны тов, шүүх бүрэлдэхүүн, хэргийг хэлэлцэх үндэслэл, шийдвэрийн тоймыг нэгдмэл стандартаар, тогтмол, дэлгэрэнгүй нийтэлж хэвшсэнээр бид нээлттэй байдлаа илүү боловсронгуй болгох дараагийн шатны арга хэмжээг авч хэрэгжүүлэх нөхцөл бүрдлээ.

Үүнд одоо хэрэгжүүлж буй “шүүхийн шийдвэрийг олон нийтэд энгийн ойлгомжтойгоор хураангуйлан тоймлож хүргэх”, “хуралдааныг шууд

дамжуулах"-аас гадна олны анхаарал татсан хэргийн талаар хэвлэлд нээлттэй мэдээлэл өгөх тогтолцоо, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа хамаарна.

Өнгөрсөн онд Улсын дээд шүүхээс нэвтрүүлэг, видео, зураг, постер зэрэг хэлбэрүүдээр нийт 974 мэдээллийг телевиз, цахим хуудас, олон нийтийн цахим сүлжээгээр хүргэжээ. 2025 онд иргэдийн эрх зүй, шүүхийн боловсролыг дээшлүүлэх зорилготой “Шүүхийн боловсрол” хөтөлбөрийг 3 дахь жилдээ хэрэгжүүлэх явцад байгууллагын цахим хуудасны “Таны эрх зүйн боловсролд” цэс дэх шүүхийн талаарх 9 видео бичлэгийг дохионы хэл рүү хөрвүүлэв.

Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор хуулийг зөв хэрэглэх талаар 2 албан ёсны тайлбарыг нэмж гаргасан бөгөөд шүүгчийн сургалтын хөтөлбөр, шүүхээс нийтэлж буй нэвтрүүлэг, шийдвэрийн тоймуудад хууль хэрэглээний зөрүүг арилгах, шүүхийн шийдвэрийн онол-арга зүйн түвшнийг дээшлүүлэх агуулга тогтмол тусгагдаж байна. Өнгөрөгч оны байдлаар Монгол Улсын дээд шүүхийн шийдвэрийн 58 тоймыг цаасан болон цахим хэлбэрээр эмхэтгэж иргэд, хуульчдын гарт ойртуулснаас гадна Эрүүгийн хэргийн танхимаас авлигын гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн 56 тогтоолыг сонгож нийтэлсэн нь энэ төрлийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хэн бүхэнд хуулийн хэрэглээг зөв ойлгох ач холбогдолтой.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд эрүүгийн 947, иргэний 1261, захиргааны 479 гомдлыг танхимууд нийт шүүгчийн хурлаараа хэлэлцэж 469 хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар тус тус хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

Шүүх эрх мэдлийн дээд байгууллага болохынхоо хувьд Улсын дээд шүүх эрх зүйг хөгжүүлэх үйл ажиллагаанд онцгой ач холбогдол өгч ажилладаг бөгөөд өнгөрсөн онд Нийт шүүгчийн 15 хуралдаанаар 88 асуудал хэлэлцсэнээс 11 хуулийн төслийн талаар албан ёсны саналаа хууль тогтоогчид хүргүүлсэн байна.

2025 онд шүүхийн гадаад харилцааг хөгжүүлэх бодлого улам эрчимжиж Нидерландын Хаант Улс, Бельгийн Хаант Улс, Люксембургийн Их Гүнт Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс, Бүгд Найрамдах Сингапур улсуудын шүүхийн дээд байгууллагатай албан ёсны хоёр талт хэлэлцээ хийж шүүхийг хөгжүүлэх, сургалт, судалгааны чиглэлд хамтран ажиллахаар боллоо. Европын холбооны “Твиннинг” хөтөлбөр үргэлжилж, Канад Улсын

Гадаад хэргийн яамны дэмжлэгтэй “Тэгш эрх, шударга ёсыг хүн бүрд” төсөл хэрэгжиж эхлэв.

Мөн олон улс дахь иргэдийн шүүхээр хамгаалуулах эрхийн хамгаалалтад тулгарч буй сорилтыг даван туулах, шүүхийн хөгжлийн чиг хандлагын талаар ялгаатай эрх зүйн систем, туршлага бүхий улсуудаас хуран цугларсан шүүгч, хуульч эрдэмтдийн хамтаар хэлэлцэж шинжлэх ухаанч бодлого, шийдвэр боловсруулах арга хэмжээг үргэлжлүүлэн авч хэрэгжүүллээ. Тухайлбал, “Дагнасан шүүхийн тогтолцоо: Хүүхдийн эрх ашиг ба гэр бүл”, “Шүүхийн бие даасан, хараат бус байдал ба шүүхийн цахимжилт” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлуудад Монгол, Австрали, ХБНГУ, Япон, Нидерланд, БНСУ, БНТУ, АНУ, Канад зэрэг улсуудын төлөөлөл оролцов.

Улсын дээд шүүхээс хуульд заасан чиг үүргээ шуурхай, үр нөлөөтэй хэрэгжүүлэх үүднээс иргэд, сэтгүүлч, судлаачид болон бусад талуудтай холбогдох уулзалт хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Тухайлбал, “Шүүхийн ил тод байдал-Хэвлэл мэдээллийн хамтын ажиллагаа”, “Улс төрийн намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэхэд анхаарах асуудал”, “Сэтгэцэд учруулсан хор уршгийг арилгуулах эрх зүйн орчин: Асуудал, шийдэл” сэдэвт уулзалт, хэлэлцүүлгүүд шүүхийн мэдээллийг иргэд үнэн бодит эх сурвалжаас шуурхай авах, хуулиар тогтоосон бүртгэлийг хуульд заасан шаардлага, хугацаанд гүйцэтгэх, иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээх эрх зүйн орчныг сайжруулахад чухал нөлөөтэй.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасан шүүн таслах ажлын чанар, үр нөлөөний үнэлгээг олон улсын туршлага, өөрийн улсын онцлогт нийцүүлсэн арга зүйд тулгуурлан анх удаа гүйцэтгэв. Шүүх хуралдаанд биечлэн оролцсон, шүүхийн үйлчилгээг газар дээр нь авсан иргэд, хуульчдын сэтгэл ханамжийн үнэлгээ 50 хувиас хавьгүй дээгүүр үнэлэгдсэн бөгөөд цаашид уг арга зүйд тулгуурласан үнэлгээг улс даяар хэрэгжүүлэхэд анхаарал хандуулж байна.

Өмнөх жилүүдийн үйл ажиллагааны тайланг бид хураангуй болон дэлгэрэнгүй хэлбэрээр тогтмол нийтэлж буй бөгөөд Улсын дээд шүүхийн шүүгчдийн илтгэл, ярилцлага, иргэд, салбарынхаа хуульчдад хандсан бусад мэдээлэлтэй бидний цахим хуудаснаас нээлттэй танилцах боломжтой. Та бүхний оюун тунгалаг байж, эх орондоо шударга ёсыг хангах үйлсэд санаа зорилго нэгтэй оролцохыг хүсье.

Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч  
**ДАМДИНЫ ГАНЗОРИГ**



## УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН БҮРЭЛДЭХҮҮН



### ШҮҮГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- Хууль зүйн дээд боловсролтой;
- Мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан;
- Гучин таван нас хүрсэн;
- Монгол Улсын иргэнийг Улсын дээд шүүхийн шүүгчээр томилно.



### ШҮҮГЧИЙН ТОМИЛГОО

- Улсын дээд шүүхийн шүүгчийг Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын Их Хуралд танилцуулснаар Монгол Улсын Ерөнхийлөгч томилно.



### ЕРӨНХИЙ ШҮҮГЧИЙН ТОМИЛГОО

- Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроос зургаан жилийн хугацаагаар Монгол Улсын Ерөнхийлөгч томилно.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд зааснаар Улсын дээд шүүх нь Ерөнхий шүүгч, хорин дөрвөн шүүгчээс бүрддэг. Иргэний хэргийн танхимын шүүгч П.Золзаяа Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр, мөн танхимын шүүгч Г.Цагаанцоож Шүүхийн сахилгын хорооны гишүүнээр ажиллаж байна.



**ЕРӨНХИЙ ШҮҮГЧ** Дамдины ГАНЗОРИГ (2013 оноос Улсын дээд шүүхийн шүүгч, 2020 оноос Ерөнхий шүүгч)

**ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАНХИМ**

- Танхимын тэргүүн Чагдаагийн ХОСБАЯР (2015 оноос Улсын дээд шүүхийн шүүгч, 2021 оноос Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн)
- Шүүгч Батаагийн БАТЦЭРЭН (2013 оноос)
- Шүүгч Баттогоогийн ЦОГТ (2013 оноос)
- Шүүгч Болдын АМАРБАЯСГАЛАН (2019 оноос)
- Шүүгч Сосорбурамын СОЁМБО-ЭРДЭНЭ (2021 оноос)
- Шүүгч Мөнхөөгийн ПҮРЭВСҮРЭН (2022 оноос)
- Шүүгч Цогийн ОЧ (2025 оноос)

**ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАНХИМ**

- Танхимын тэргүүн Гүррагчаагийн АЛТАНЧИМЭГ (2015 оноос Улсын дээд шүүхийн шүүгч, 2021 оноос Иргэний хэргийн танхимын тэргүүн)
- Шүүгч Батсүрэнгийн УНДРАХ (2005 оноос)
- Шүүгч Хуушааны ЭРДЭНЭСУВД (2013 оноос)
- Шүүгч Дашхүүгийн ЦОЛМОН (2013 оноос)
- Шүүгч Нямдоогийн БАЯРМАА (2022 оноос)
- Шүүгч Нэргүйн БАТЧИМЭГ (2023 оноос)
- Шүүгч Намсрайн БАТЗОРИГ (2023 оноос)
- Шүүгч Энэбишийн ЗОЛЗАЯА (2025 оноос)

**ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМ**

- Танхимын тэргүүн Дашдоржийн МӨНХТУЯА (2013 оноос Улсын дээд шүүхийн шүүгч, 2022 оноос Захиргааны хэргийн танхимын тэргүүн)
- Шүүгч Мишигийн БАТСУУРЬ (2013 оноос)
- Шүүгч Пүрэвдоржийн СОЁЛ-ЭРДЭНЭ (2015 оноос)
- Шүүгч Гочоогийн БАНЗРАГЧ (2016 оноос)
- Шүүгч Цэндийн ЦОГТ (2020 оноос)
- Шүүгч Дэмбэрэлийн БАТБААТАР (2022 оноос)



## ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ ТООН МЭДЭЭЛЭЛ

# ТАНХИМЫН НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН ХЭРЭГ \_\_\_\_.

Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч гомдол гаргасан хэргийг танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэнэ. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5-д зааснаар дараах тохиолдолд хэргийг хяналтын журмаар хянан шийдвэрлэнэ:

➔ Шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах

➔ Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн

➔ Хуулийг Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбараас өөрөөр хэрэглэсэн

➔ Эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой

### ТАНХИМЫН НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН ХЭРГИЙН ТОО

Эрүүгийн хэргийн  
танхим

 **947**

Хуульд заасан үндэслэлээр давж заалдах журмаар хянан хэлэлцэх шүүх хуралдаанаар

**17** хэрэг

Иргэний хэргийн  
танхим

 **1261**

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулахаар гаргасан хүсэлт хэлэлцэх хуралдаанаар

**38** хэрэг

Захиргааны хэргийн  
танхим

 **546**


Сахилгын хэрэг хянан хэлэлцэх шүүх хуралдаанаар

**1** хэрэг

# ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХ ХУРАЛДААНААР ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРЭГ

## ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАНХИМ


132 хэргийг шийдвэрлэсэн байдал



- Тогтоол, магадлалыг хэвээр үлдээж, гомдол, эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгосон
- Тогтоол, магадлалд өөрчлөлт оруулсан
- Тогтоол, магадлалыг хүчингүй болгосон

## ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАНХИМ


236 хэргийг шийдвэрлэсэн байдал



- Шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхисон
- Шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулсан
- Шийдвэр, магадлалыг хүчингүй болгосон

## ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМ

101 хэргийг шийдвэрлэсэн байдал





- Шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхисон
- Шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулсан
- Шийдвэр, магадлалыг хүчингүй болгосон



# ХЯНАЛТЫН ЖУРМААР ГАРГАСАН ГОМДЛЫГ ТАНХИМЫН НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦЭХ ПРОЦЕСС (21 хоногийн дотор)



# ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХ ХУРАЛДААНААР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ПРОЦЕСС (30 хоногийн дотор)





# ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ДУНДАЖ ХУГАЦАА

## ЭРҮҮГИЙН ХЭРЭГ

Хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцсэн 132 хэргээс нэг хэргийг хянан шийдвэрлэсэн дундаж хугацаа 23 хоног байна.



Дундаж хугацаа

## ИРГЭНИЙ ХЭРЭГ

Хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцсэн 236 хэргээс нэг хэргийг хянан шийдвэрлэсэн дундаж хугацаа 17.8 хоног байна.



Дундаж хугацаа

## ЗАХИРГААНЫ ХЭРЭГ

Хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцсэн 101 хэргээс нэг хэргийг хянан шийдвэрлэсэн дундаж хугацаа 27 хоног байна.



Дундаж хугацаа

## САХИЛГЫН ХЭРЭГ

Улсын дээд шүүхийн хянан шийдвэрлэсэн 1 сахилгын хэргийг хянан шийдвэрлэсэн дундаж хугацаа 16 хоног байна.



Дундаж хугацаа

# УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ТОЙМ

## Эрүүгийн хэргийн шийдвэрийн тоймоос

**Эрүүл мэндийн асуумжаа үнэн зөв мэдүүлээгүйгээс үүссэн эрсдэлийг эмч хүлээхгүй. 2025/ХШТ/101 (эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг)**

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн их эмч Г.Х, Э.Н нар нь яаралтай дуудлагын дагуу очиж эмчийн үзлэг хийхдээ, өвчтөний биеийн болон эмнэл зүйн байдлыг бүрэн гүйцэт үнэлэлгүй, холбогдох харьяа дүүргийн Нэгдсэн эмнэлгийн яаралтай тусламжийн тасагт тээвэрлэн хүргээгүйн улмаас иргэн Б.О нас барсан гэмт хэрэгт холбогджээ.

Анхан болон давж заалдах шатны шүүх дээрх нэр бүхий эмч нарыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 15.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан “Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс хохирогч нас барсан” гэм буруутайд тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн байна.

Улсын дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар Г.Х-ийн гаргасан гомдлыг үндэслэн хэргийг хянан хэлэлцээд анхан болон давж заалдах шатны шүүх хэргийн үйл баримтыг сэргээн тогтоосон дүгнэлт хэргийн бодит байдалтай нийцээгүй гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэлээ.

Учир нь, Г.Х, Э.Н нар нь түргэн тусламжийн тусгай дугаар 103-т хандсан яаралтай бус хүлээгдэлтэй дуудлагад хамаарах хам шинж /бөөлжих, халуурах/ -тэй өвчтөнд эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ үйлчлүүлэгчийн биеийн байдлыг нь асуумжид тулгуурлан тогтоож, амин үзүүлэлт, эмнэл зүйн шинжийг нь харгалзан өөрийн мэдлэг, дадлага туршлагад үндэслэн зохих тусламж, үйлчилгээг үзүүлсэн гэж үзэх үндэслэлтэй.

Өөр өөр дуудлагын дагуу тус тусдаа ирсэн эмч нарыг биечлэн үзлэг хийх үед өвчтөний амь тэнссэн буюу амь нас эрсдэх, амин эрхтний үйл ажиллагаа зогсох аюул шууд заналхийлж, эмнэлгийн сэхээн амьдруулах тусламжийг хойшлуулшгүйгээр 2-5 минутын дотор эхлэх шаардлага үүсээгүй байсан тул эмнэлгийн яаралтай тусламжийн тасагт тээвэрлэж хүргээгүй, тээвэрлэх бэлэн байдлыг хангуулж гараас гарт хүлээлгэн өгөөгүй

гэж буруутгах нөхцөл байдал тогтоогдоогүй.

Мөн нас барсан хохирогч болон түүний ар гэрийнхэн түргэн тусламжийн эмчийн өвчний шалтгаан, зовуурийг оношлох зорилгоор асуусан асуумжид үнэн зөв хариулаагүй, бодит зүйлийг нууж хэлээгүйн улмаас хордлогын шалтгаант өвчнийг оношилж чадаагүй эмч нарыг үйлчлүүлэгчийн биеийн байдал болон эмнэл зүйн байдлыг бүрэн гүйцэт үнэлж чадаагүй, эмнэлгийн тусламж үзүүлээгүй гэж дүгнэх боломжгүй юм.

Түргэн тусламжийн төвийн их эмч Э.Н, Г.Х нарыг эмчийн тангаргаа сахиж, эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээг зохих ёсоор буюу өвчтөнөөс авсан асуумжид тулгуурлан өвчтөний биеийн байдлыг үнэлж, өвчний хам шинжийг тодорхойлж зөвлөгөө, заавар өгч, бөөлжилтийн эсрэг тариа хийх зэргээр үзлэгийг зохих ёсоор бүрэн хийж гүйцэтгэсэн тул тэдэнд холбогдох Эрүүгийн хуулийн тусгай ангийн 15.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан хэргийг гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, шүүгдэгч нарыг цагаатгахаар шийдвэрлэсэн болно.

Их эмч Г.Х нь ажлын ачааллаас болж түргэн тусламжийн хуудсыг тухайн өдөртөө бичиж амжилгүй нөхөн бүртгэхдээ үйлчлүүлэгчийн зовуурийг андуурч буруу бичсэн үйлдлийг ажил үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй бус харин гүйцэтгэсэн ажлаа тайлагнах явцад гаргасан мэргэжлийн алдаа гэж үзэх тул Хөдөлмөрийн болон бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэх эсэх нь ажил олгогчийн эрх хэмжээнд хамаарах асуудал болохыг тэмдэглэн дурджээ.

ХЯНАЛТЫН ШАТНЫ  
ШҮҮХИЙН ТОГТООЛ





# УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ТОЙМ

## Иргэний хэргийн шийдвэрийн тоймоос

### Хүүхдийн тэтгэлэг төлж байгаа нь нэмэлт зардлаас чөлөөлөгдөх үндэслэл болохгүй. 001/ХТ2025/00095 (гэр бүлийн эрх зүйн маргаан)

Нэхэмжлэгч шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ: "...2022.09.22-ны өдрийн шүүхийн шийдвэрээр гэрлэлтээ цуцлуулж, хүүхдүүдийг миний асрамжид үлдээж шийдвэрлэсэн бөгөөд хүүхдүүд миний асрамжид эрүүл энх өсөн бойжиж, сургуульд төлбөртэйгөөр суралцаж байна.

Гэрлэлт цуцалснаас хойш би 4 хүүхдийн сургалтын төлбөрт нийт 18,380,000 төгрөгийг төлсөн ба төлбөрийн 50 хувь болох 9,190,000 төгрөгийг хүүхдүүдийн эцгээс гаргуулах, 4 хүүхдэд тэтгэлэг тогтоолгохоор нэхэмжилж байна..." гэж тайлбарласан,

Хариуцагч шүүхэд гаргасан хариу тайлбартаа: "...2022-2023 оны хичээлийн жилийн сургалтын төлбөрийг би бүгдийг нь төлсөн, ...хэдэн оны сургалтын төлбөр нэхэмжилж байгаа нь тодорхойгүй, сургалтын төлбөр бол зайлшгүй зардал биш тул хүлээн зөвшөөрөх боломжгүй. Мөн хүүхдийн тэтгэлэг гаргуулах тухай нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй, бага охин Г.Ц, хүү Г.А нарыг өөрийн асрамжид авах хүсэлтэй байна..." гэж маргажээ.

Анхан шатны шүүх: "...Гэр бүлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 26 дугаар зүйлийн 26.2.2-т зааснаар эцэг, эх хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх үүрэгтэй, ...эцэг, эх тусдаа амьдарсан ч асарч хамгаалах, тэжээн тэтгэх, анхаарал халамж тавих үүрэг хэвээр үргэлжилнэ, ...Гэр бүлийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд зааснаар хариуцагчаас хуульд заасан хэмжээгээр тэтгэлэг гаргуулан, ...хүүхдүүдийг тэжээн тэтгүүлэхээр шийдвэрлэнэ. ...Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгодог байхад хувийн сургуульд хүүхдүүдийг суралцуулж байгаа нь эцэг, эхийн сайн дурын асуудал байх бөгөөд хувийн сургуульд сургасан төлбөрөө хариуцагчаас нэхэмжилж байгаа нь нэмэлт зардал гэж үзэх үндэслэлгүй ...Иймд сургалтын төлбөр шаардсан нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгоно..." гэж дүгнэж, Гэр бүлийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1, 40.1.2-т зааснаар хариуцагчаас сар бүр тэтгэлэг гаргуулан тэжээн тэтгүүлж, нэхэмжлэлийн шаардлагаас хүүхдийн сургалтын төлбөрт 9,190,000 төгрөг гаргуулах шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Нэхэмжлэгчийн өмгөөлөгч "...шүүх төрөөс суурь боловсролыг төлбөргүй олгодог гэх үндэслэлээр хүүхдүүдийн сургалтын төлбөрт 9,190,000 төгрөг гаргуулах шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэснийг зөвшөөрөхгүй..." гэж давж заалдах журмаар гомдол гаргасан.

Давж заалдах шатны шүүх хэргийг хянаад: "...шүүх Гэр бүлийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1, 40.1.2 дахь хэсэгт зааснаар 4 хүүхдийн тэтгэлгийг хариуцагчаас гаргуулан шийдвэрлэсэн нь үндэслэлтэй, ...хүүхдийг сурган хүмүүжүүлэх, боловсрол эзэмших, хөгжиж төлөвшихөд нь туслах эцэг, эхийн үүргийн хүрээнд төлбөртэй сургуулийг сонгон суралцуулсанд нэхэмжлэгчийг буруутгах үндэслэлгүй. ...Иймд 2023-2024 оны сургалтын төлбөрийг зайлшгүй гарсан нэмэлт зардалд тооцож, уг зардлын тал хувийг хариуцагчид хариуцуулах нь Гэр бүлийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэгт заасантай

нийцнэ..." гэж дүгнэж, Гэр бүлийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-д зааснаар хүүхдийн сургалтын төлбөрт 9,190,000 төгрөг гаргуулахаар өөрчлөлт оруулж, гомдлыг хангаж шийдвэрлэсэн.

Магадлалыг эс зөвшөөрч хариуцагч Б.Г-аас "...том хүү 18 насанд хүрсэн байхад тэтгэлэг гаргуулахаар шийдвэрлэсэн нь үндэслэлгүй, ...сургалтын төлбөрийг нэмэлт зардалд оруулан тооцсоныг зөвшөөрөхгүй..." гэх үндэслэлээр хяналтын журмаар гомдол гаргасан.

Хяналтын шатны шүүх хэргийг хэлэлцээд: "...Нэхэмжлэгч хариуцагчаас гэрлэлтээ цуцлуулснаас хойш буюу 2023-2024 оны хичээлийн жилд 4 хүүхдийн сургалтын төлбөрт нийт 18,380,000 төгрөгийг төлсөн, төлбөрийн тал хувийг хариуцагч хариуцах үүрэгтэй гэх үндэслэлээр хариуцагчаас 9,190,000 төгрөгийг шаардсан байх ба давж заалдах шатны шүүх дээрх төлбөрийг хариуцагчаас гаргуулж нэхэмжлэгчид олгуулахаар шийдвэрт өөрчлөлт оруулахдаа үндэслэл бүхий дүгнэлт хийсэн.

Хэдийгээр төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгодог боловч зохигч гэрлэлтээ цуцлуулахаас өмнө хүүхдүүд тухайн төлбөртэй сургуульд суралцаж байсан, төлбөрийг гэр бүлийн орлогоос төлж байсан тул хүүхдүүдийг төлбөртэй сургуульд сургахаар эцэг, эх нь харилцан тохиролцсон байсан гэж үзнэ.

Хуульд зааснаар эцгээс олгож буй тэтгэлэг нь тэдний идэж, уух хоол хүнс, өмсөх хувцас, хичээлийн хэрэглэл зэрэг өдөр тутмын хэрэгцээнд зарцуулагдах бөгөөд тэтгэлэг төлж байгаа нь нэмэлт зардал болох сургалтын төлбөрөөс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй тул энэ талаар гаргасан хариуцагчийн гомдол үндэслэлгүй.

Харин Гэр бүлийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д хүүхдэд олгох тэтгэлгийн хэмжээг түүний насны байдлыг харгалзан тогтоохоор заасан ба 40.1.2-т насны дээд хязгаарыг "суралцаж байгаа бол 18 настай" гэж, харин насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй бол тэтгэлэг тогтоохоор зохицуулсан. Нэхэмжлэгчийн том хүү Г.А 2006.08.19-ний өдөр төрсөн ба анхан шатны шүүхийн шийдвэр гарах 2024.12.25-ны өдөр 18 насанд хүрсэн байгааг шүүх анхаараагүй, тэрээр хөдөлмөрийн чадваргүй гэх үндэслэл тогтоогдоогүй байхад түүнд тэтгэлэг тогтоож шийдвэрлэсэн нь хуулийн дээрх зохицуулалтад нийцээгүй..." гэж дүгнэн энэ талаарх хариуцагчийн гомдлыг хангаж, нэхэмжлэлийн шаардлагаас Г.А-д тэтгэлэг тогтоосон хэсгийг хэрэгсэхгүй болгохоор анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж шийдвэрлэв.

ХЯНАЛТЫН ШАТНЫ  
ШҮҮХИЙН ТОГТООЛ



# УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ТОЙМ

## Захиргааны хэргийн шийдвэрийн тоймоос

### Хууль үйлчлэх үед ажиллаж байсан алба хаагч урамшуулал авах эрхтэй. 001/ХТ2025/0034 (төрийн алба)

Нэхэмжлэгч Б-ээс Онцгой байдлын ерөнхий газарт холбогдуулан “30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгохоос татгалзсан шийдвэр хууль бус болохыг тогтоож, мөнгөн урамшуулал олгохыг даалгуулах”-аар шүүхэд нэхэмжлэл гаргасан байна.

Тэрбээр нэхэмжлэлдээ: “...Гамшгаас хамгаалах тухай хуульд зааснаар аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй 5 болон түүнээс дээш жил ажилласан онцгой байдлын албан хаагчид 5 жил тутамд 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал авах эрхтэй. Миний бие онцгой байдлын албанд нийт 10 жил, 9 сар ажилласан тул урамшуулал авахаар Онцгой байдлын ерөнхий газарт хүсэлтээ өгсөн боловч татгалзсан. Урамшуулал авах хуулийн заалт хэрэгжиж эхлэх үед би тус албанд ажиллаж байсан тул урамшуулал авах эрхтэй гэж үзэж байна, иймд нэхэмжлэлийг хангаж өгнө үү...” гэжээ.

Хариуцагч нэхэмжлэлийг эс зөвшөөрч “... Мөнгөн урамшуулал авах алба хаагчдын урьдчилсан судалгааг нягтлах, тооцоог хийх, тушаал, шийдвэрийн бүрдлийг хангах, санхүүжилтийн зарцуулалтын эрх нээлгэх зэрэг ажлаас хамаарч 2023 оны 10 дугаар сараас урамшууллыг олгож эхэлсэн. Засгийн газрын 2022 оны 188 дугаар тогтоолоор зохицуулаагүй зарим асуудлыг Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 78 дугаар тушаалаар баталсан “Онцгой байдлын байгууллагад алба хаах журам”-д нэмэлт оруулж “Урамшуулал авах эрх үүссэн боловч албанаас чөлөөлөгдсөн, сахилгын шийтгэлээр болон хуульд заасан бусад үндэслэлээр халагдсан, тэтгэвэрт гарсан тохиолдолд урамшууллыг нөхөж олгохгүй...” гэж нарийвчлан зохицуулсан. Б нь урамшуулал олгох үед онцгой байдлын албанаас чөлөөлөгдсөн байсан тул урамшуулал олгох үндэслэлгүй...” гэж маргасан.

Анхан болон давж заалдах шатны шүүх “хариуцагчийн татгалзал хууль ёсны байна” гэж дүгнэн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосныг Улсын дээд шүүхээс хуулийг буруу тайлбарлан хэрэглэсэн гэж дүгнэн, шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэв.

Учир нь, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.11 дэх хэсэгт “Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа онцгой байдлын байгууллагын алба хаагчид ... урамшууллыг олгоно” гэснийг “тухайн хууль болон Монгол Улсын Засгийн газрын журам

үйлчилж эхлэх үед ажиллаж байгаа хуулийн шаардлага хангасан алба хаагч” гэж тайлбарлах нь хуулийн зорилго, агуулгад нийцэхээр байна.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн дээрх заалт нь 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдөр нэмэлтээр орсон бөгөөд үүнтэй холбоотой журмыг батлах эрхийг Монгол Улсын Засгийн газарт хуулиар олгосон. Үүний дагуу Засгийн газар 2022 оны 188 дугаар тогтоолоор урамшуулал олгох журам баталж, уг журмыг 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхэлж дагаж мөрдөхөөр заажээ.

Хууль болон Засгийн газрын журамд хуулийн шаардлага хангасан боловч урамшуулал олгох үед онцгой байдлын албанаас шилжсэн, чөлөөлөгдсөн алба хаагчид урамшуулал олгохгүй байх талаар заагаагүй. Харин ч Засгийн газрын баталсан журмын 2.1-д “Онцгой байдлын байгууллагын алба хаагч аймгийн төвөөс бусад суманд томилогдсон өдрөөс эхлэн тасралтгүй 60 сар ажилласан бол түүнд таван жил тутамд нэг удаа мөнгөн урамшуулал олгоно” гэж тусгайлан заажээ.

Нэхэмжлэгч Б нь онцгой байдлын албанд (аймгийн төвөөс бусад суманд) тасралтгүй 10 жил, 9 сар ажилласан, дээрх хууль болон Засгийн газрын журам үйлчилж эхлэх үед онцгой байдлын албанд ажиллаж байсан тул урамшуулал авах хуулийн урьдчилсан нөхцөлийг хангасан гэж үзнэ.

Харин хариуцагчийн татгалзлын үндэслэл болсон Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 78 дугаар тушаалаар баталсан журмын тухайд, Гамшгаас хамгаалах тухай хуульд зааснаар урамшуулал олгохтой холбоотой журмыг Засгийн газар батлах эрхтэй. Гэтэл Шадар сайд өөрт эрх олгогдоогүй асуудлаар журам баталсан нь “хуульд үндэслэх” зарчимд нийцэхгүй тул журмын холбогдох заалтыг хэрэглэхгүй.

Иймд нэхэмжлэгчийг хуульд заасан урамшуулал авах эрхтэй гэж үзэв.

ХЯНАЛТЫН ШАТНЫ  
ШҮҮХИЙН ТОГТООЛ





## ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНААС БУСАД АЖЛЫН ТООН МЭДЭЭЛЭЛ

### НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААН, ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨГӨӨН

#### УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ БҮРЭН ЭРХ

- Хуулиар харьяаллыг нь тогтоогоогүй эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоох;
- Улсын дээд шүүхийн танхимын шүүх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй болсон тохиолдолд шүүх бүрэлдэхүүнийг томилох;
- Шүүхийн шийдвэр, практикт үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг гаргах;
- Хууль тогтоомжийн төслийн талаарх саналаа хууль санаачлагчид хүргүүлэх зэрэг 11 асуудал хамаардаг.

Нийт шүүгчийн **15** удаагийн хуралдаанаар **88** асуудлыг хэлэлцсэн.

Тайлбар  
**2**

Хуулийн төсөлд  
өгсөн санал  
**23**

Бусад  
**41**

Улс төрийн  
намын өргөдөл  
**19**

Хууль тогтоомжийг  
боловсронгуй болгох санал  
**3**

#### ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨГӨӨН

Шүүгчдийн зөвлөгөөн Улсын дээд шүүхийн нийт шүүгчээс бүрдэх ба хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхээс бусад асуудлаар буюу шүүхийн дотоод ажлын зохион байгуулалт, журмыг тогтоох, шүүх хуралдаан даргалагчийн дарааллыг тогтоох зэрэг Монгол Улсын

шүүхийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-т заасан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэдэг.

2025 онд Улсын дээд шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөн 8 удаа хуралдаж 21 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

## УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНААС 2025 ОНД ХУУЛИЙГ ЗӨВ ХЭРЭГЛЭХ ТАЛААР ДАРААХ 2 АЛБАН ЁСНЫ ТАЙЛБАРЫГ ГАРГАСАН БАЙНА



Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17.2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг тайлбарлах тухай  
2025.05.01 дугаар 23.



Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.23 дахь заалтыг тайлбарлах тухай.  
2025.05.01 дугаар 28.

## ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ БОЛОН ШҮҮХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЭРХ ЗҮЙН БАЙДАЛТАЙ ХОЛБОГДСОН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ХУУЛЬ САНААЧЛАГЧИД ХҮРГҮҮЛСЭН САНАЛ:

### Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам болон шүүхийн үйл ажиллагаа, эрх зүйн байдалтай холбогдсон асуудлаар:

- Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
- Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл;
- Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдуулан боловсруулсан Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
- Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон түүнтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл;
- Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;
- Эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төсөл;
- Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
- Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төсөл болон Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
- Арилжааны анхдагч хуулийн төсөл;

- Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
- Худалдан авах ажиллагааны тухай хуулийн төсөл;
- Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төсөл;
- Орон сууцны болон орон сууцны бус зориулалттай байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн менежментийн тухай хуулийн төсөл.



### Хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар:

- Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийг нөхөн төлүүлэхтэй холбоотой зарим хууль, холбогдох журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
- Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.






## ЧУУЛГАН, ОЛОН УЛСЫН ХУРАЛ, УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

### НИЙТ ШҮҮГЧИЙН ЭЭЛЖИТ III ЧУУЛГАН

Монгол Улсын шүүхийн тухай хуульд бүх шатны шүүхийн нийт шүүгчээс бүрдсэн Нийт шүүгчийн чуулганыг хоёр жил тутам зохион байгуулахаар заасны дагуу ээлжит III чуулган 2025 оны 10 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдав.

Чуулганыг Улсын дээд шүүхийн шүүгч, Нийт шүүгчийн чуулганыг зохион байгуулах Ажлын хэсгийн ахлагч Б.Батцэрэн нээж, чуулганы хуралдаан даргалагчаар Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын шүүгч Ц.Цогт, дэд даргалагчаар Иргэний хэргийн танхимын тэргүүн Г.Алтанчимэг нар сонгогдов.

Чуулганаар хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нийтлэг журамд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар, шүүх эрх мэдлийн хүрээнд дагаж мөрдөх хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудал, шүүхийн тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааг боловсронгуй болгох, шүүгчийн эрх ашгийг хамгаалах, сахилга хариуцлагыг сайжруулах зэрэг дөрвөн үндсэн агуулгын хүрээнд илтгэл тавьж, хэлэлцүүлэв.



Нийт шүүгчийн III чуулган



Зургаадугаар сарын 16-17

### “ШҮҮХИЙН ХАРААТ БУС БАЙДАЛ БА ЦАХИМЖИЛТ” СЭДЭВТ ОЛОН УЛСЫН БАГА ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Улсын дээд шүүх, Шүүхийн академи, Шүүхийн ерөнхий зөвлөл болон АНУ-ын Элчин сайдын яам хамтран АНУ-ын Конгрессын дэргэдэх “Олон улсын манлайллын төв”-өөс (COIL-Congressional Office for International Leadership) шүүхийн салбарт хэрэгжүүлдэг “Нээлттэй дэлхий” хөтөлбөрийн Төгсөгчдийн хуралдааныг “Шүүхийн хараат бус байдал ба цахимжилт” сэдвийн дор зохион байгуулав.



Зургаадугаар сарын 25

### “ДАГНАСАН ШҮҮХИЙН ТОГТОЛЦОО: ХҮҮХДИЙН ЭРХ АШИГ БА ГЭР БҮЛ” СЭДЭВТ ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүх байгуулахтай холбогдуулан Улсын дээд шүүх, Шүүхийн академи, Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага болон Ханнс-Зайделийн сан хамтран “Дагнасан шүүхийн тогтолцоо: Хүүхдийн эрх ашиг ба гэр бүл” олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр зохион байгууллаа.

Хуралд Монгол, Австрали, ХБНГУ, Япон, Нидерланд, БНСУ, БНТУ, АНУ зэрэг найман орны шүүгч, эрдэмтэн, судлаачид “Гэр бүл ба хамтын амьдрал, үрчлэлт, гэрлэлт цуцлалт, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхол, асран хамгаалалт, дундын эд хөрөнгийн харилцаан дахь тулгамдсан асуудал”, “Өсвөр насны хүнд холбогдох хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа”, “Гэр бүл, хүүхдийн хэргийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ба шүүхийн бүтэц, зохион байгуулалт” зэрэг сэдвийн хүрээнд танхим болон цахим хэлбэрээр оролцож, илтгэл хэлэлцүүлэн, харилцан туршлага солилцов.





## “ШҮҮХИЙН ИЛ ТОД БАЙДАЛ - ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА” УУЛЗАЛТ

Монгол Улсын дээд шүүх, Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага /IDLO/-тай хамтран “Шүүхийн ил тод байдал-Хэвлэл мэдээллийн хамтын ажиллагаа” уулзалтыг 2025 оны 10 сарын 21-ний өдөр зохион байгууллаа.

Уулзалтад Улсын дээд шүүхийн шүүгч Б.Батцэрэн, Тамгын газрын дарга С.Заяадэлгэр тэргүүтэй холбогдох мэргэжилтнүүд, Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагын суурин төлөөлөгч Чарльз Болланд болон тус байгууллагын төлөөллүүд, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн академийн холбогдох албаныхан, шүүхүүдийн Тамгын газрын дарга нар мөн Олон нийттэй харилцах ажилтнууд, төрийн бус байгууллагуудын төлөөлөл, сэтгүүлчид зэрэг 40 орчим хүн оролцов.



“Шүүхийн ил тод байдал-Хэвлэл мэдээллийн хамтын ажиллагаа” уулзалт

## "ШҮҮХИЙН ЦАХИМЖИЛТ, ШУУД ДАМЖУУЛАЛТ"-ЫН ТАЛААР СЭТГҮҮЛЧИДТЭЙ УУЛЗЛАА

Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр тэргүүтэй төлөөлөгчид сэтгүүл зүйн салбарын төлөөлөлтэй 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдөр уулзалт зохион байгуулж, шүүх хуралдааны шууд дамжуулалт, цахимжилт, шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах хүрээнд хийж хэрэгжүүлж буй ажил болон бусад үйл ажиллагааны чиглэлээр мэдээлэл өгч, сэтгүүлчидтэй бусад улсын нээлттэй шүүхийн сайн жишгээс судлах зэрэг бусад асуудлаар санал солилцов.



“Шүүхийн цахимжилт, шууд дамжуулалт” уулзалт



## “ШҮҮХИЙН ШИЙДВЭР БИЧИХ АРГАЧЛАЛ: ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛТЭЙ ХОЛБООТОЙ ТОГТООХ ХЭСЭГ” УУЛЗАЛТ

Монгол Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимаас “Шүүхийн шийдвэр бичих аргачлал: Шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой тогтоох хэсэг” сэдэвт уулзалт, ярилцлагыг Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 70 гаруй шүүгчдийг оролцуулан зохион байгууллаа.

Уулзалтын үр дүнд “Шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийг тодорхой болгож, шаардлагатай тохиолдолд дэлгэрүүлэхээр санал нэгдэв. Мөн оролцогчдын зүгээс ЗХШХШТХ-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл бүлэгт өөрчлөлт оруулах төслийн талаар байр сууриа илэрхийлж, боловсронгуй болгох тал дээр тогтож ярилцав.



“Шүүхийн шийдвэр бичих аргачлал: Шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой тогтоох хэсэг” уулзалт, ярилцлага

## “СЭТГЭЦЭД УЧРУУЛСАН ХОР УРШГИЙГ АРИЛГУУЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН: АСУУДАЛ, ШИЙДЭЛ” ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Монгол Улсын дээд шүүхээс “Сэтгэцэд учруулсан хор уршгийг арилгуулах эрх зүйн орчин: Асуудал, шийдэл” хэлэлцүүлгийг 2025 оны 05 дугаар сарын 25-ны өдөр зохион байгууллаа.

Улсын дээд шүүхийн Эрүү, Иргэний хэргийн танхимын шүүгчид, анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчид, Монгол Улсын Их Хурал, Хууль зүй, дотоод хэргийн яам, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын Ерөнхий Прокурорын газар, Шүүх шинжилгээний ерөнхий газар, Монголын Хуульчдын холбоо, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, АНУ-ын Спурлок сан, Нээлттэй нийгэм форум, Ханс-Зайделийн сан, Оюуны-Инноваци ТББ, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Японы эрх зүйн төв болон бусад их дээд сургуулийн эрдэмтдийн төлөөлөл зэрэг 240 орчим оролцогч хэлэлцүүлэгт танхим болон цахимаар оролцов.



“Сэтгэцэд учруулсан хор уршгийг арилгуулах эрх зүйн орчин: Асуудал, шийдэл” хэлэлцүүлэг



## “ТАТВАРЫН МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ЧАДАВХЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ” СУРГАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ



“Татварын маргаан шийдвэрлэх чадавхыг дээшлүүлэх” сургалт, хэлэлцүүлэг

Олон Улсын OECD байгууллагаас хэрэгжүүлдэг Олон улсын татварын эрх зүй: чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд Франц Улсын Төрийн зөвлөл, Олон Улсын Энергийн Агентлагтай хамтран, Парис хотод зохион байгуулсан Захиргааны хэргийн шүүгч нарт зориулсан “Татварын маргаан шийдвэрлэх чадавхыг дээшлүүлэх” сургалт, хэлэлцүүлэгт Захиргааны хэргийн танхимын тэргүүн, шүүгч Д.Мөнхтуяа “Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг шилжүүлэхтэй холбоотой татварын маргаан шийдвэрлэсэн зарим тохиолдол: Монгол Улсын жишээн дээр” илтгэл хэлэлцүүлэв.



## ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Улсын дээд шүүх нь хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, хүний эрх, хууль дээдлэх ёсыг сахин хамгаалах байр суурийг илэрхийлэх, харилцан идэвхтэй оролцоог хангах замаар харилцан ашигтай, хамтын ажиллагааг хөгжүүлэхийг эрмэлзэж ажиллав.

Гуравдугаар сарын 13-20

### МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ Д.ГАНЗОРИГ БЕНИЛЮКСИЙН ОРНУУДАД АЛБАН ЁСНЫ АЙЛЧЛАЛ ХИЙЛЭЭ.




Нидерландын Хаант Улс, Бельгийн Хаант Улс, Люксембургийн Их Гүнт Улсад 2025 оны 03 дугаар сард албан ёсоор айлчилж, эдгээр орнуудын Дээд шүүхийн Ерөнхийлөгч нартай хоёр талын хэлэлцээ хийж, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.

Айлчлалын үр дүнд Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн академи болон Нидерландын Хаант Улсын Ассерийн Академи хооронд сургалт, судалгаа, академик солилцооны асуудлаарх санамж бичгийг байгуулж, Олон улсын эрүүгийн шүүхэд Улсын дээд шүүхээс дадлагажигч ажиллуулах, Нидерландын Хаант Улсын Гаагийн олон улсын эрх зүйн академийн хөтөлбөрүүдэд Монгол Улсын шүүгчдийг хамруулах, Монгол Улсад зохион байгуулах олон улсын эрдэм шинжилгээний хурлуудад салбарын шилдэг судлаачдыг оролцуулах зэрэг асуудлаар тохиролцоонд хүрэв.



Зургаадугаар сарын 09

### МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ, БҮГД НАЙРАМДАХ СОЦИАЛИСТ ВЬЕТНАМ УЛСЫН АРДЫН ДЭЭД ШҮҮХТЭЙ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА



Монгол Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ой, Ардын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Ле Мин Чий-гийн Монгол Улсад хийж буй албан ёсны анхны айлчлалыг тохиолдуулан хамтран ажиллах, харилцан ойлголцлын санамж бичиг байгууллаа.

Санамж бичгийн хүрээнд талууд шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагаа, шүүх эрх мэдлийн хүрээнд хийгдсэн шинэчлэл, шүүхийн цахимжилт, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зэрэг асуудлын хүрээнд харилцан туршлага судлах, сургалт, судалгааг хөгжүүлэх, мэдээлэл солилцож, хамтран ажиллахаар тохиролцов.

Долоодугаар сарын 04

### МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ, БҮГД НАЙРАМДАХ СИНГАПУР УЛСЫН ДЭЭД ШҮҮХТЭЙ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА

Хамтын ажиллагааны хүрээнд шүүхийн цахимжилт, шүүгчийн сургалт, дагнасан шүүхийн тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар харилцан ойлголцлын санамж бичиг байгуулав.



# ШҮҮХ ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ ЕВРОПЫН ХОЛБООНЫ ТВИННИНГ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

Улсын дээд шүүх болон Европын Холбоо хамтран “Монгол Улсын шүүх эрх мэдлийн шинэтгэлийг үр дүнтэй хэрэгжүүлэх нь” хосолмол түншлэлийн төслийг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд албан ёсны нээлт 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдөр боллоо.

Нээлтийн үйл ажиллагаанд төслийг хэрэгжүүлэгч Европын холбооны гишүүн улс болох ХБНГУ-ын төрийн өндөр албан тушаалтнууд болон Монгол Улсын дээд шүүх, Шүүхийн академи, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн Сахилгын Хороо тэргүүтэй шүүх эрх мэдлийн байгууллагууд, Монгол Улс дахь Европын Холбооны мөн ХБНГУ-ын Элчин сайдын яам, дипломат төлөөлөгчийн газрууд, бусад холбогдох байгууллагын төлөөлөл оролцлоо.

Монгол талын төслийн удирдагчаар Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Д.Ганзориг, төслийн нэгдүгээр бүрэлдэхүүн хэсгийн ахлагч болон байнгын зөвлөхийн хамтрагчаар шүүгч Ц.Цогт ажиллаж байна.



## ТӨСЛИЙН ЗОРИЛГЫГ ХАНГАХАД ДАРААХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛНЭ

1. Шүүгчийн чадавх, шүүхийн шийдвэрийн чанарыг сайжруулна
2. Шүүхийн тогтолцооны гүйцэтгэл, хариуцлагыг нэмэгдүүлнэ
3. Шүүхийн тогтолцооны хүртээмжтэй байдал, шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлнэ.

## “ШҮҮГЧИЙН ЧАДАВХ, ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ” ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:

1. Улсын дээд шүүхийн судлаач туслахуудын ур чадварыг хөгжүүлснээр хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад хувь нэмэр оруулах;
2. Шүүхийн академитай хамтран институцийн чадавхыг бэхжүүлэх, шүүгчдийн сургалтын чанарыг дээшлүүлэх чиглэлд ажиллах;
3. Шүүгчдэд тодорхой сэдвийн дагуу сургалт явуулах.

## ХҮЛЭЭГДЭХ ҮР ДҮН:

- Шүүн таслах ажиллагааны чанар сайжирсан байна.
- Шүүхийн академийн ур чадвар, чадавхыг нэмэгдүүлсэн байна.
- Хууль хэрэглээний нэгдмэл байдал, хуулийн хэрэгжилтийг сайжруулахад хувь нэмэр оруулсан байна.

## Аравдугаар сарын 06

### “ТЭГШ ЭРХ, ШУДАРГА ЁСЫГ ХҮН БҮРД” ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ ЭХЭЛЛЭЭ

Канад Улсын Гадаад хэргийн яамны дэмжлэгтэйгээр таван жилийн хугацаанд хэрэгжих бөгөөд төслийн хүрээнд шүүхийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгох, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, ялангуяа охид, эмэгтэйчүүд зэрэг эмзэг бүлгийн гишүүдийн шүүхэд мэдүүлэх эрхийн баталгааг хангахад чиглэсэн үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэхээр тогтов.





## УЛС ТӨРИЙН НАМЫН БҮРТГЭЛ

### “УЛС ТӨРИЙН НАМЫН ДҮРМИЙГ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭН БҮРТГҮҮЛЭХ АСУУДАЛ” УУЛЗАЛТ

Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газраас Сонгуулийн ерөнхий хороотой хамтран “Улс төрийн намын дүрмийн нэмэлт, өөрчлөлт (Шинэчилсэн найруулга)-ийг бүртгүүлэхэд анхаарах асуудал” уулзалтыг 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр зохион байгууллаа.

Уулзалтад Улсын дээд шүүхийн шүүгч, Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, шүүгч П.Соёл-Эрдэнэ, Э.Золзаяа, Тамгын газрын дарга С.Заяадэлгэр болон холбогдох албаны мэргэжилтнүүд, Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ, тус хорооны Улс төрийн намын мэдээлэл, арга зүйн газрын дарга Д.Баяндүүрэн, Улс төрийн намын санхүүжилт, хяналтын газрын дарга Н.Булгамаа тэргүүтэй төлөөлөгчид, мөн Улсын дээд шүүхэд бүртгэлтэй улс төрийн намуудын төлөөлөл зэрэг нийт 60 орчим хүн оролцов.



“Улс төрийн намын дүрмийн нэмэлт, өөрчлөлт (Шинэчилсэн найруулга)-ийг бүртгүүлэхэд анхаарах асуудал” уулзалт



# УЛС ТӨРИЙН НАМЫН БҮРТГЭЛИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ


Улсын дээд шүүхээс 2025 онд улс төрийн намын бүртгэлтэй холбоотой 48 өргөдөл; лавлагаа, мэдээлэл олгох, бүртгэл хөтлөхтэй холбогдуулан 91 албан бичиг; нийт 139 өргөдөл, хүсэлтийг хүлээн авч, 127 өргөдөл, хүсэлтийг шийдвэрлэсэн байна.

Улс төрийн намаас ирүүлсэн өргөдлийг 2024 оны мөн үетэй харьцуулахад 54.2 хувиар өссөн нь Улсын дээд шүүхэд бүртгэлтэй улс төрийн намууд “намын дүрэм”-ийг хуульд нийцүүлэн шинэчлэн бүртгүүлэх үүрэг хүлээсэнтэй холбоотой юм.



**УЛС ТӨРИЙН НАМЫН  
ГИШҮҮДИЙН БҮРТГЭЛИЙГ  
ХУР СИСТЕМЭЭР ДАМЖУУЛАН  
ШАЛГАДАГ БОЛЛОО**

УЛС ТӨРИЙН НАМААС ИРҮҮЛСЭН ӨРГӨДЛИЙГ  
2024, 2025 ОНЫ ХАРЬЦУУЛСАН ҮЗҮҮЛЭЛТ:




Шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах ажлын хүрээнд Улсын дээд шүүхийн [www.supremecourt.mn](http://www.supremecourt.mn) цахим хуудаст Улс төрийн намын бүртгэлтэй холбоотой мэдээ, мэдээллийг QR кодоор харих боломжтойгоор байршуулав.



## ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛД

# ШҮҮГЧ БОЛОН ХУУЛЬЧДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТ



Улсын дээд шүүхийн шүүгч Б.Батцэрэн, Б.Амарбаясгалан, Ц.Оч, Иргэний хэргийн танхимын тэргүүн Г.Алтанчимэг, шүүгч Н.Баярмаа, П.Золзаяа, Н.Батзориг, Э.Золзаяа, Д.Цолмон, Ц.Цогт, Г.Банзрагч, М.Батсуурь, Н.Батчимэг, П.Соёл-Эрдэнэ, Х.Эрдэнэсүвд, Б.Ундрах нар хууль тайлбарлан хэрэглэх онол, арга зүй, хэргийн хөдөлгөөний удирдлага, тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа болон шүүхийн ил тод байдалтай холбоотой шинэлэг зохицуулалтын хэрэгжилт, анхаарах асуудал, шүүхийн шийдвэрийн хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлага, анхаарах асуудал, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтын онцлог хэрэглээ, нэмэлт, өөрчлөлт, нийтийн ашиг сонирхлыг төлөөлж гаргасан нэхэмжлэл, анхаарах асуудал зэрэг сэдвээр анхан шатны шүүхэд шинээр томилогдсон шүүгч, анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдэд сургалт зохион байгуулав.

“Гомдол, мэдээллийн дагуу мөрдөн шалгах ажиллагаа явуулахад анхаарах асуудал”, “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийг шалгаж, шийдвэрлэхэд анхаарах асуудал”, “Итгэлийг хамгаалах зарчим”, “Хүний сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлүүлэхтэй холбоотой асуудлууд”, “Захиргааны байгууллагын хяналтын цар хүрээ” зэрэг сэдвээр өмгөөлөгч болон хуульчдад сургалт зохион байгуулав.

Улсын дээд шүүхийн шүүгч Б.Амарбаясгалан “Хуульчийн мэргэжлийн шалгалтын сорилго-2025”, шүүгч Б.Батцэрэн “Шүүгчийн ёс зүй, зан байдал”, Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяа “Захиргааны хэргийн шүүх 2024 тайлан сэтгүүл”, шүүгч Г.Банзрагч “Эрх зүйт төр ба шүүх эрх мэдэл”, шүүгч Ц.Цогт “Захиргааны эрх зүйн системчлэл, хэрэглээ: Харилцан хамаарал” зэрэг ном, гарын авлагыг эрхлэн гаргав.

## УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭЭС ГАРГАСАН НОМ, ЭМХЭТГЭЛ

Эрүүгийн хэргийн танхимын хянан шийдвэрлэсэн тогтоолын эмхэтгэл (Авлигын гэмт хэрэг)



Монгол Улсын дээд шүүхийн шийдвэрийн тойм (эмхэтгэл)



Монгол Улсын дээд шүүх 2024 тайлан




Захиргааны хэргийн шүүх 2024



Supreme court of Mongolia танилцуулга

# ОЛОН НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛД

Улсын дээд шүүхийн цахим хуудас ([www.supremecourt.mn](http://www.supremecourt.mn))-д “Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэд”-д зориулсан цэс үүсгэж, шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, тэдний эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, түүнчлэн шүүхийн үйл ажиллагааг таниулах зорилгоор “Таны эрх зүйн боловсролд” цуврал 9 видео бичлэгийг дохионы хэл рүү хөрвүүлэн (<https://www.supremecourt.mn>) байршуулж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэв.



Нийслэлийн Ерөнхий боловсролын 23-р сургуулийн 12-р ангийн сурагчид Улсын дээд шүүхийн үйл ажиллагаатай танилцав.



МУИС-ийн Хууль зүйн сургуулийн V түвшний оюутнууд Улсын дээд шүүхийн үйл ажиллагаатай танилцав.



Шихихутуг их сургуулийн II түвшний оюутнууд Улсын дээд шүүхийн үйл ажиллагаатай танилцав.



Нийслэлийн Ерөнхий боловсролын 52-р сургуулийн ахлах ангийн сурагчид Улсын дээд шүүхийн үйл ажиллагаатай танилцав.



МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Төвийн солилцооны зуны сургалтад хамрагдсан БНСУ-ын Күүмин их сургуулийн оюутнууд Улсын дээд шүүхийн үйл ажиллагаатай танилцав.



МУИС-ийн Хууль зүйн сургуулийн V түвшний оюутнууд Улсын дээд шүүхийн үйл ажиллагаатай танилцав.



## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР



Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газар шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүх хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд мэдээлэл, судалгаа, санхүү, аж ахуй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж, дэлгэрэнгүй тайланг олон нийтэд цахим хуудсаар мэдээлж, энэхүү товхимлоор онцлох ажлын болон шаардлагатай мэдээллийг товчлон хүргэхийг зорилгоо.

Монгол Улсын дээд шүүх “шинэ” байранд нүүж орсон буюу хуучнаар нийслэлийн төр захиргааны

“Хангарди ордон (Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Бага тойруу 15160, Ц.Жигжиджавын гудамж 7/1)”-ыг шилжүүлэн авч, шүүхийн байрны стандартад нийцүүлэн бүрэн засварлаж, ашиглалтад оруулснаар, хяналтын шатны эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүх хуралдааныг нэгэн зэрэг товлон явуулах боломжийг бүрдүүлж, иргэдэд үйлчлэх хэсэг, прокурор, хэргийн оролцогч, өмгөөлөгчдийн хэрэгтэй танилцах өрөө зэргийг тохижуулж, шүүхийн үйлчилгээний орчин, нөхцөлийг сайжруулсан нь манай хамт олны хувьд түүхэн чухал үйл явдал боллоо.

Тамгын газар нь Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан удирдамжийн дагуу “Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэг”-т хамрагдаж, 99 оноо авч, өмнөх улсын үзлэгээр 92 оноотой дүгнэгдэж байсан амжилтаа ахиулсан нийт хамт олондоо энэ дашрамд баяр хүргэн, талархал дэвшүүлье.

Шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангаж, Улсын дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдааныг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нээлттэй дамжуулах хуулийн хэрэгжилтийн хүрээнд эрүүгийн 140, захиргааны 142, иргэний 282, нийт 564 хяналтын шатны шүүх хуралдааныг цахим хуудсаараа шууд дамжуулж, иргэд, олон нийтэд тухай бүр хүргэж ажилласан нь тус Тамгын газрын хувьд техник технологи, хүний нөөцийн чадавх, бэлэн байдлыг шаардсан чухал арга хэмжээний нэг байв.

Монгол Улсын дээд шүүх, түүний Танхимуудын санаачилга, удирдамж чиглэлийн дагуу “Дагнасан шүүхийн тогтолцоо: Хүүхдийн эрх ашиг ба гэр бүл”, “Шүүхийн хараат бус байдал ба цахимжилт”, “Цахим эрх зүй, түүний хөгжлийн чиг хандлага” зэрэг олон улсын эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөнүүдийг Шүүхийн академитай хамтран амжилттай зохион байгууллаа.

Хуулийг зөв хэрэглэх, шүүхийн шийдвэрийг судалгааны эргэлтэд оруулах, шүүгчдийн тойм бичих арга зүйг хөгжүүлэхэд дэмжлэг болох зорилгоор Улсын дээд шүүхээс гаргасан 58 шийдвэрийн тойм, мөн Эрүүгийн хэргийн танхимаас 2017-2025 онд хянан шийдвэрлэсэн авлигын гэмт хэргийн тогтоолуудыг эмхэтгэн, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тууштай тэмцэх ач холбогдол бүхий судалгааны эх сурвалж болгон тус тус хэвлэн гаргалаа.

Монгол Улсын дээд шүүхээс 2025 онд улс төрийн намын бүртгэлтэй холбоотой 48 өргөдөл; лавлагаа, мэдээлэл олгох, бүртгэл хөтлөхтэй холбогдуулан 91 албан бичиг; нийт 139 өргөдөл, хүсэлтийг хүлээн авснаас 127 өргөдөл, хүсэлтийг шийдвэрлэсэн байна. Улс төрийн намаас ирүүлсэн өргөдлийн тоог 2024 оны мөн үетэй харьцуулахад 54.2 хувиар өссөн үзүүлэлтэй байгаа нь Улс төрийн намын тухай хуулийн шинэчлэл болон дагаж мөрдөх журмын дагуу намууд дүрмээ хуульд нийцүүлэн шинэчлэн бүртгүүлэх үүрэгтэй холбоотой юм.

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн зарим зүйл, заалт Үндсэн хуульд нийцээгүй үндэслэлээр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргаснаар төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоос “нэгдсэн холбоог бүртгүүлэх”-ээр ирүүлсэн 15 хүсэлт түдгэлзсэн байна. Улсын дээд шүүхийн Тамгын газрын хувьд бүртгэлтэй холбоотой баримт бичгийг хууль тогтоомжид нийцэж буйг хянах илүү хариуцлагатай үүрэг хүлээсэн жил болж өнгөрлөө.



Шүүхийн хэвийн үйл ажиллагааг хангах, судалгааны үр дүнг дээшлүүлэх, төрийн үйлчилгээнд цахимжуулалт, хиймэл оюуны хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр одоогийн нөхцөл байдлын үнэлгээ, технологи ба хүний нөөцийн хэрэгцээ, зорилтот стратегийг тодорхойлох цогц ажлууд хийгдэж, байгууллагын хэмжээнд ашиглагдах системүүдийн архитектур, хүчин чадал, өгөгдлийн уялдаа, дотоод интеграци, шинэчлэл хийх боломжийг техникийн түвшинд тодорхойлов.

Байгууллагын цахим хуудаст байршуулсан хяналтын тогтоолуудад хиймэл оюунд суурилсан утгачилсан хайлт хийх боломжтой хөгжүүлэлтийг хийж, хэрэглээнд нэвтрүүлэв.

Мөн системүүдийн хооронд өгөгдөл солилцох үйл явц, метадатагийн бүтэц, өгөгдлийн чанар болон давхардлын түвшинг үнэлж, үйл ажиллагааны давхардал, автоматжуулалтын боломж, хүний оролцоо өндөр байгаа ажлуудыг тодорхойлж, хиймэл оюунд суурилсан мэдээллийн технологи, шүүхийн үйлчилгээнд цахимжуулалтыг нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн санаачилга, манлайллын хүрээнд эхлүүлсэн Европын холбоотой хамтарсан “Монгол Улсын шүүх эрх мэдлийн шинэтгэлийг үр дүнтэй хэрэгжүүлэх нь” хосолмол түншлэлийн төсөл, Канад Улсын Холбооны шүүхийн Хэрэг эрхлэх газартай хамтран “Тэгш эрх, шударга ёсыг хүн бүрд” төслийг амжилттай хэрэгжүүлэх, Сингапур Улсын дээд шүүх, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Ардын дээд шүүхтэй тус тус хамтран ажиллах санамж бичиг байгуулах ажлуудыг зохион байгуулж, шүүхийн олон улс, бүс нутгийн харилцаа холбоог хөгжүүлэх бодлогыг боловсруулан ажиллаж байна.

Монгол Улсын дээд шүүхийн хэрэгцээнд зориулсан номын сан нь гадаад хэл дээрх 2300, дотоодын 4000 гаруй номтой. Номын сангийн сан хөмрөгийг хууль эрх зүйн чиглэлийн ховор ном, товхимлоор өргөжүүлэх, хууль зүйн ном бүтээл эрхлэн гаргадаг байгууллагууд ном бүтээл, цахим эх сурвалж солилцох, номын сангаа хөгжүүлэхэд арга туршлагаа хуваалцах, судалгааны эргэлтэд оруулах чиглэлээр холбогдох байгууллагуудтай уулзалт зохион байгуулж, хамтын ажиллагааг эхлүүлснийг онцлон дурдъя.

2025 онд Улсын дээд шүүхийн үйл ажиллагааны чанар, үр нөлөөг АНУ, Европын холбоо зэрэг олон улсын туршлага, өөрийн орны онцлогийг уялдуулсан арга зүйгээр анх удаа үнэлж, Шүүгчдийн зөвлөгөөнд танилцууллаа. Үүнд шүүхийн чанарын 250 үзүүлэлт бүхий шалгах хуудсыг ашиглаж цаашид бодлогын түвшинд анхаарах саналуудыг боловсруулснаас гадна иргэд, хуульчдын сэтгэл ханамжийн үнэлгээг асуумжийн аргаар цуглуулж дүгнэв. Улсын дээд шүүхээр үйлчлүүлсэн иргэдийн сэтгэл ханамж нийт 17 хүчин зүйлийн дунджаар 86.3%-тай үнэлэгдлээ. 2026 онд уг үнэлгээний арга зүйг бусад шүүхэд хэрэгжүүлэхэд анхааран ажиллах нь зүйтэй юм.

Цаашид “Шүүхэд итгэх иргэдийн итгэлийн нэмэгдүүлэх” зорилгын хүрээнд шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдал, цахимжилт, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, шүүхийн төсвийг боловсруулах процедур, үр нөлөөг сайжруулах, хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэхэд онцгойлон анхаарч ажиллах болно.

Танд ажлын өндөр амжилт хүсэн ерөөе.

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
**С.ЗАЯАДЭЛГЭР**



## ШҮҮХ ХУРАЛДААНЫ ШУУД ДАМЖУУЛАЛТ

Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасны дагуу Улсын дээд шүүх 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн шүүх хуралдааныг шууд дамжуулж, Эрүүгийн хэргийн танхимын 140, Иргэний хэргийн танхимын 282, Захиргааны хэргийн танхимын 142, нийт 564 хяналтын шатны шүүх хуралдааны шууд дамжуулалт (LIVE)-ыг байгууллагын <https://www.supremecourt.mn> цахим хуудас болон фэйсбүүк пэйж хуудсаар хийж, иргэд, олон нийтэд мэдээллийг шуурхай хүргэн, шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангаж ажиллав.


Монгол Улсын шүүхийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд шүүх хуралдааны тов, шүүх бүрэлдэхүүн, хэргийн оролцогч, тухайн хэргийг хэлэлцэх үндэслэл, шүүх хуралдааны явц болон хэргийг хэрхэн шийдвэрлэсэн тухай тойм зэрэг мэдээллийг байгууллагын цахим хуудсаар тогтмол мэдээлж ажилласан.



Шууд дамжуулалт







Шүүх хуралдааны зар



# ШҮҮХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДАЛ

 <p>www.supremecourt.mn идэвхтэй хэрэглэгч <b>237,000</b></p>	 <p>“Supremecourt of Mongolia” инстаграмм хаягийн дагагч <b>400</b></p>	 <p>Монгол Улсын дээд шүүх Facebook хуудасны дагагч <b>24,213</b></p>	 <p>“Supremecourt of Mongolia” youtube сувгийн дагагч <b>812</b></p>
---	--	--	---

 <p><b>84</b> “Шүүхийн цаг” нэвтрүүлэг /аудио, видео/</p>	 <p><b>5</b> “Хүүхэд асууж байна” нэвтрүүлэг</p>	 <p><b>406</b> Постер, текст мэдээ</p>
 <p><b>3</b> “Шүүгчийн онцолсон ном” нэвтрүүлэг</p>	 <p><b>70</b> Видео мэдээ</p>	 <p><b>564</b> Шууд дамжуулалт</p>



Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан албан хаагчид.




## МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ЦАХИМЖУУЛАЛТ



Улсын дээд шүүхийн судалгааны чанар, үр нөлөөг дээшлүүлэх, шүүхийн үйл ажиллагаанд дэвшилтэт технологийг үе шаттайгаар нэвтрүүлэх зорилтын хүрээнд хиймэл оюун ухааныг ашиглах боломж, шаардлага, өнөөгийн нөхцөл байдлын үнэлгээ, технологийн дэд бүтэц, хүний нөөцийн хэрэгцээ, цаашдын хөгжлийн зорилтот чиглэлийг тодорхойлох цогц арга хэмжээг хэрэгжүүлсэн болно. Энэ хүрээнд байгууллагын дотоод хөгжүүлэлтийн чадамжид тулгуурлан шүүхийн онцлог хэрэгцээнд нийцсэн мэдээллийн систем, технологийн шийдлүүдийг хөгжүүлэх үйл

ажиллагааг эрчимжүүлж, хиймэл оюун ухааны загварыг хөгжүүлэх чиглэлээр олон улсын туршлагыг судлах, суурь судалгааг гүйцэтгэх, шаардлагатай өгөгдлийн бэлтгэлийг хангах ажлыг зохион байгуулав.



Түүнчлэн шүүхийн мэдээллийн аюулгүй байдал, өгөгдлийн бүрэн бүтэн байдал, тасралтгүй ажиллагааг хангах, цаашид хиймэл оюун ухаанд суурилсан шийдлүүдийг дотоод орчинд найдвартай байршуулан ажиллуулах техникийн нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор олон улсын шаардлагад нийцсэн дата төвийн орчныг бүрдүүлсэн.

“Монгол Улсын дээд шүүхийн шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг томилох журам”-ын шаардлагад нийцүүлэн илтгэгч шүүгч болон шүүх бүрэлдэхүүнийг урьдчилан мэдэх боломжгүй, тойргийн хүрээнд санамсаргүй байдлаар хуваарилан томилох ажиллагааг хангах системийг хөгжүүлж, үйл ажиллагаанд нэвтрүүлэв. Мөн Улс төрийн намын бүртгэлийн системийг сайжруулж, төрийн мэдээлэл солилцооны ХУР системтэй холбогдсон нэмэлт хөгжүүлэлтүүдийг хийж гүйцэтгэв. Үүнээс гадна байгууллагын дотоод хэрэгцээнд нийцсэн бусад мэдээллийн систем, программ хангамжийг үе шаттайгаар хөгжүүлж, нэвтрүүлж байгаа нь шүүхийн үйл ажиллагааны ил тод, хараат бус байдал, мэдээллийн аюулгүй байдал, нэгдмэл байдлыг хангах, дотоод чадавхыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

# УЛСЫН ДЭЭД ШҮҮХ БАЙРШЛАА ӨӨРЧИЛЛӨӨ

Улсын дээд шүүхийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор хуучнаар нийслэлийн төр захиргааны байрыг шүүхийн байрны стандартад нийцүүлэн бүрэн засварлаж, 2025.09.01-ний өдөр ашиглалтад оруулав.

Улсын дээд шүүхийн байр, шүүх хуралдааны танхимын стандартыг ханган, шүүхийн байранд үзмэрийн танхим, номын санг ажиллуулж, тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан тохижилтыг хийж, иргэдэд ээлтэй орчныг бүрдүүлэв.



Хуралдааны танхим.



Улсын дээд шүүхийн үзмэрийн танхим.



Улсын дээд шүүхийн номын сан.



Танхимын хүлээлгийн хэсэг.






## УЛСЫН ҮЗЛЭГТ 99 ОНООТОЙ ДҮГНЭГДЛЭЭ

Улсын дээд шүүхийн архив нь анх 1927 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр байгуулагдсан бөгөөд архивын баримтыг он цаг, зохион байгуулалт, асуудал сэдэв, хэргийн төрөл, ач холбогдлоор нь ялгаж, Үндэсний төв архивт нөхөн бүрдүүлэлт хийх ажлыг 2025 онд зохион байгууллаа.

Улсын дээд шүүхийн архив 1974-2005 оны 184 хэрэг 355 хадгаламжийн нэгж, 2013-2024 оны байнга хадгалах 2012 хадгаламжийн нэгж, 1980-2023 оны 70 жил хадгалах 90 хадгаламжийн нэгж, 1994-2023 оны түр хадгалах 2022 хадгаламжийн нэгжтэй.

Тамгын газар нь 2025 онд “Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэг”-т хамрагдаж, 99 оноотой дүгнэгдэн өмнөх амжилтаа ахиулав.

*Улсын дээд шүүхийн Тамгын газар 399 өргөдөл, гомдол, 1323 албан бичиг хүлээн авч, 5182 албан бичгийг явуулж, 943 албан бичгийг үндэсний бичгээр хөтлөв.*




АЙЖ ЦОЧИН  
ХЭРЭГ ХҮЛЭЭХ ХЭРЭГГҮЙ  
АЙЛТГҮЙ ҮНЭНЭЭ ХЭЛ

ШИХИХУТУГ  
(1180-1262)





 51-261698, 51-261544

 [info@supremecourt.mn](mailto:info@supremecourt.mn)

 [www.supremecourt.mn](http://www.supremecourt.mn)

 @supremecourtmn

 @supremecourtof\_mongolia

 @Монгол Улсын дээд шүүх

